

МУЗЕЙН ҮЗҮҮЛЛЭГ

I. Үзүүлэг зохион байгуулахад шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх нь

1. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Музейн аливаа эд зүйлийг тодорхой зорилго чиглэлтэйгээр нийтэд дэлгэн харуулсныг ҮЗҮҮЛЛЭГ гэнэ. Музейн үзүүлэг нь зохион байгуулалт, хадгалалт хамгаалалт, тавилт өрөлтийн онцлогтой. Үүнд:

1. Үзүүлэгт тохиолдлын чанартай юм бүхнийг бус, харин үзэгчдэд түүхэн үйл явдал, байгалийн үзэгдлийн талаар мэдээлэл өгч, түүнтэй харилцан холбоотой болохыг нь мэдрүүлэн сэтгэлийг нь хөдөлгөж хоногшин үлдэхээр эд зүйлийг тавина.
2. Музейн үзүүлэгийн үндэс нь музейн хамт олон, эрдэм шинжилгээний ажилтнуудын боловсруулсан шинжлэх ухааны концепци /үзэл санаа, үзэл баримтлал, чиглэл/ юм. Энэ концепци нь үзүүлэгийн агуулга, цуглуулгаас сонгож авах, бүлэглэх зарчим, зохиомж, тайлбар, ялангуяа уран сайхны шийдлийг тодорхойлдог.

Үзэгчид музей үзэхдээ тавигдсан үзмэрийг янз бүрээр хүлээж авах боловч мэдээлэл авч, чөлөөт цагаа өнгөрөөж, идэвхтэй амардаг.

Үзүүлэгт тавигдсан музейн эд зүйл нь шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулагдсан цогц зүйл тул цуглуулгаас өөр шинж чанартай. Эд зүйл нь цуглуулгыг тусгах боловч тодорхой сэдвийг нээн харуулдаг. Эд зүйлийг дэглэхдээ үзэгчдийн хүлээн авах чадвар олж авах мэдээлэл, сургалт сурталчилгаа, хүмүүжил гоо сайхны боловсролын боломжийг харгалзана.

Тиймээс үзүүлэгт тавигдах эд зүйлийг сонгож авахдаа:

1. Мэдээллийн эх сурвалжийнх нь хувьд нарийн сонгож авах.
2. Сонирхол татахуйц / аттрактивность/
3. Утга төгөлдөр санаа илтгэсэн /экспрессивность/
4. Үзүүлэгт тавигдах газар
5. Уран сайхны дизайны /чимэглэлийн / шинж төрх
6. Тавигдах тайлбар зэргийг тодорхой судална.

ОУМЗ-ийн “Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах сэргээн засварлах харти” –д /2.8/... Үзүүлэгийг дэглэж байгуулах, байнгын ба түр үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгуулж, хүмүүсийн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, шинэ мэдээлэл түгээх нь сан хөмрөгийг ашиглах гол хэлбэр мөн. ... Дээрх үйл ажиллагаа /үзүүлэг/ сан хөмрөгт харш нөлөөлөхгүй хохирол учруулахгүй байх ёстой. Үзэсгэлэн үзүүлэгээр дамжин байгаа мэдээлэл нь үлгэр домгийг мөнхжүүлэх бус тодорхой бодитой байна гэж заасан байдаг.

Мөн тавихаасаа өмнө засаж, сэргээн засварлаж, үзмэрийн танхимд удаан тавихад бэлтгэсэн байх ёстой. Ремонт- засах, реставраци- анхны байдалд эргэн оруулах.

Ийнхүү эд зүйл үзүүлэгт тавигдсанаар мэдээллийн эх сурвалжийн байдлаасаа хальж үзүүлэгийн идэвхтэй харилцан үйлчлэл бүхий хэсэг, сэтгэл хөдлөлийг үүсгэгч ҮЗМЭР болж хувирдаг.

Музейн үзүүлэг эд зүйлд тулгуурлахаас гадна үзүүлэн таниулах- эрдэм шинжилгээний туслах материалыг ашигладаг. Туслах материал нь музейн

боловсрол хүмүүжлийн үүргийг гүйцэтгэхэд үүрэгтэй. Ишлэл, нэр хаяг, танилцуулга зэрэг тайлбар нь янз бүрийн шинж төрх, зориулалттай байна. Эдгээр нь бүгд үзүүлэгийн утга санаа мөн чанарыг тодорхойлж өгөх ҮЗҮҮЛЛЭГИЙН МАТЕРИАЛ болдог. Үзүүлэгийн материалыг үзүүлэгийн сэдэв, зорилго, эрдэм шинжилгээний концепци, уран сайхан гоо сайхны шаардлагын дагуу бүлэг болгон зохион байгуулж байрлуулна.

Ийм нэгэн сэдэвт, харагдах байдлаараа бүхэл, тусгайлсан тодорхой тодорхой хязгаарлагдмал талбайд байрлуулсан үзүүлэгийн хэсгийг нэг цогцолбор иж үзүүлэг /комплекс/ гэнэ. Харилцан холбоотой уялдан захирагдсан хэсгүүдийн цогц нь ҮЗҮҮЛЛЭГИЙН БҮТЦИЙГ бий болгоно.

Цогцолбор бүрт тавигдсан эд зүйл нь харилцан нөлөөлж дэмжин, бодит байдлыг нь баталгаажуулж, мэдээллийг илрүүлэхээс гадна агуулга, заримдаа гоо зүйн нэгдлийг нь илэрхийлэхэд туслана. Үзмэрийг бүлэг болгох, зохиомж, уран сайхны чимэглэл хийснээр үзмэр бүр тусдаа өгөх мэдээллийг нэмэгдүүлэх, шаардлагатай тохиолдолд сулруулах бөгөөд үзүүлэгийн танин мэдэхүй, сэтгэл хөдөлгөх үнэ цэнийг ихэсгэнэ.

Үзүүлэгт эд зүйлийг янз бүрээр бүлэглэдэг. Материал нь бодит байдлын элементүүдийг харуулахаас гадна /Ж: интерьер – өрөөний дотоод байдал, ландшафтная диорама - картина, написанная с обеих сторон просвечивающей тонкой ткани, а также картина с расположенными на переднем плане объемными предметами- гэрэлтсэн нимгэн даавууны хоёр талд зурсан зураг буюу зурсан том зургийн өмнө бодит зүйлсийг тавина/ бодит байдлыг илэрхийлж чадах эд зүйлээр төлөөлүүлэн тавина. Эд зүйлийг хөдөлмөрийн үр дүн, урлагийн бүтээгдэхүүн, байгалийн хэсэг болохыг нь харуулахаар тодорхой системд байрлуулж болно. Өөрөөр хэлбэл, тодорхой системд эд зүйлийг байрлуулах нь тэдгээрийг хөдөлмөрийн үр дүн, урлагийн бүтээл, байгалийн хэсэг болохыг ойлгоход туслана. Үзүүлэгийн агуулгаас урган гарсан, шинжлэх ухааны үндэслэлээр үзүүлэгийн материалыг бүлэг болгох хуваах, зохион байгуулах дэс дарааллыг ҮЗҮҮЛЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА гэнэ.

Үзүүлэгийг зориулалтын үзэсгэлэнгийн танхимд байрлуулна. Үзмэрийн танхим нь үзэхэд хамгийн тохиромжтой байхаар тоноглогдох бөгөөд гоо зүй, сэтгэл зүйн нөлөө үзүүлэхүйц орчин бүрдүүлнэ. Үүний тул арга хэрэгсэлийн бүхэл бүтэн системийг хэрэглэнэ. Үзүүлэгийн элемент, бүлэг, танхим бүр агуулгаасаа нөхцөлдсөн АРХИТЕКТУР –УРАН САЙХНЫ ШИЙДЛИЙГ олсон байна.

Ийнхүү музейн үзүүлэг нь түүний нийгэмтэй харилцан үйлчлэх /боловсрол, хүмүүжлийн/ зорилтыг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр юм. Энэ боловсрол хүмүүжлийн үндсэн үүргийг музейгээс боловсруулсан шинжлэх ухааны концепци, орчин үеийн архитектур -уран сайхны шийдлийн дагуу зохион байгуулж, тайлбарлаж, эд зүйлийг дэлгэн харуулах замаар хэрэгжүүлнэ.

Музейн байнгын үзүүлэгээс гадна түр үзэсгэлэн зохион байгуулдаг. Суурин болон явуулын үзэсгэлэн нь орчин үеийн тулгамдсан асуудлууд-улс төрийн томоохон үйл явдал, тэмдэглэлт ой, цаг үеийн мэдээлэлд зориулагдана. Үзэсгэлэн нь музейн цуглуулгыг олон нийтэд хүртээмжтэй болгож, ач холбогдлыг нь өндөрсгөн, музейн шинжлэх ухааны ололтыг эрдэм шинжилгээний эргэлтэд шуурхай оруулдаг. /хайгуулын ажлын тайлан, сэргээн засварлах ажлын тайлан, музейд авсан шинэ эд зүйл/ Үзэсгэлэнгийн түр зуурын байдал нь тавигдсан үзмэрээс харагдана. Үзэсгэлэнд хадгалалт

хамгаалалт хамгаалалтын асуудлаас шалтгаалж үзмэрт тавигдах боломжгүй эд зүйл, бусад сан хөмрөгийн эд зүйлийг тавьдаг.

Үзэсгэлэнд сонгосон сэдвийг нарийвчлан харуулах бололцоотой болдог. Зарим тохиолдолд үзэсгэлэнгийн сэдэв музейн чиглэлээс халих явдал бий. Сэдвийн тулгамдсан байдал нь үзэсгэлэнгийн архитектур – уран сайхны шийдэлд онцгой шаардлага тавьдаг. Үзэсгэлэн музейн гэгээрэл, боловсролын үүргийг их дээшлүүлж, үзэгчдийн тоог маш их нэмэгдүүлж, хамрах газар нутгийг өргөтгөдөг. Үзэсгэлэн нь өөрийн орныг гадаадад сурталчилах, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой. Үзэсгэлэнд бэлтгэх нь музейн үзүүлэлэг дэглэх ажилтай салшгүй холбоотой.

Үзүүлэлэг зохион байгуулах ажил нь музейн бүх үйл ажиллагааны огтолцох цэг болдог. Тэрээр зөвхөн гэгээрэл, боловсролын ажлын үндэс суурь болоод зогсохгүй, шинжлэх ухааны судалгааны сэдвийг сонгоход нөлөөлж, түүний үр дүн бүтээлийн нэг хэлбэр болно. Мөн үзүүлэлэг дэглэх явцад сан хөмрөгийн иж бүрдүүлэлтийн сэдэв, эд зүйлийн судалгаа, сэргээн засварлах ажлын дэс дарааллыг тодорхой хэмжээгээр тодорхойлно. Ийнхүү үзүүлэлэг зохион байгуулах ажил нь музей нийгмийн үүргээ биелүүлэх явдлыг эрчимжүүлдэг.

Гэхдээ үзүүлэлэгийн үндсэн зорилт нь тодорхой орон зайд байрлуулагдсан үзүүлэлэгийн материалыг үзэгчдэд хүргэх харилцан холбоо юм. Үзүүлэлэгийн төлөвлөгөө танхимд тодорхой хэлбэр төрхийг олдог. Үзүүлэлэгийн агуулга, хэлбэр салшгүй холбоотой тул архитектур – уран сайхны шийдэл нь музейн үзүүлэлэг зохион байгуулалтын нэг хэсэг болдог. Энэ нь музейн нэг салбар шинжлэх ухаан биш боловч уран сайхны чимэглэл, дизайны урлагт хамаарна.

Эрдэм шинжилгээний ажилтан /куратор/ зураачтай нягт хамтран ажиллаж, зарим асуудлыг хамтран шийднэ.

Орон зайн бүтээлч шийдэл, уран сайхны өндөр түвшинд хийгдсэн үзүүлэлэг, уран сайхан, техникийн төрөл бүрийн арга хэрэгслийг чадварлаг ашигласан байдал нь үзүүлэлэгийн агуулгыг нээн харуулж, үзэгчдийн сэтгэлд хоногшин үлдээнэ.

Үзүүлэлэгийн ажлын хоёр тал болох эрдэм шинжилгээ ба уран сайхны ажил нь өөрийн зорилт, онцлог шинжийг агуулна. Цаашид үзүүлэлэг дэглэлтийн энэ хоёр талыг гүйцэтгэх эрдэм шинжилгээний ажилтан, зураачийн үүргийн харилцан холбоо, хамтын ажиллагааг тайлбарлана. Гэвч үзүүлэлэг дэглэлтийг хэрэгжүүлэх хариуцлагыг музейн удирдлага хүлээнэ.

2. ТҮҮХИЙН МУЗЕЙН ҮЗҮҮЛЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРЧИМ

Аливаа улсын түүхийн музейд тухайн улсын түүхэн хөгжил, түүний олон тал, түүхэн үйл явдал, үзэгдэл тусдаг. Тэгэхдээ түүхийн үзүүлэлэг нь өнгөрсөн үе болон одоогийн амьдралыг хуулбарлан үзүүлэх зарчимд тулгуурладаггүй, ингэх ч боломжгүй. Бодит байдлыг музейд үзүүлэх тусгай аргатай байдаг. Энэ юу вэ гэвэл шинжлэх ухааны концепцийн дагуу эд зүйлээр баримтжуулдаг. Ийнхүү түүхэн бодит байдлын музейн дүр төрх бий болно. Түүхийн музейн үзүүлэлэг маш олон янз байна.

Түүнд улсын түүхийг бүхэлд нь, муж, хязгаар нутгийн түүх, нийгмийн амьдралын аль нэг талыг харуулахаас гадна үндэсний онцлог, ард түмний соёл, ахуй, соёлын харилцан нөлөөллийг /угсаатны музей/ харуулдаг. Түүхэн нэг үеийг харуулах үзүүлэлэгтэй ч байж болно. Түүхийн чиглэлийн олон музейнүүд тухайн хот, үйлдвэр, хөдөө аж ахуйн нэгдлийн түүхийг харуулдаг.

Үүний дотроос түүхэн үйл явдал, гавьяа, хүмүүст зориулан орон нутаг нь байгуулсан музей онцгой байр эзэлдэг. /дурсамжийн музей/

Үзүүлэлэг зохион байгуулалтын зарчим:

1. Түүхийн шинжлэх ухааны үндсэн зарчим нь түүхэн зарчим юм.

Энэ нь үзүүлэгийг түүхэн процессын дагуу үечлэн дэс дараалан харуулдаг.

2. Музейн мөн чанар, онцлогоос урган гарсан бодит үзмэрээр харуулах зарчим.

Энэ нь үзэгч үзүүлэлт дэглэгдсэн үзмэртэй шууд харилцах боломжтой болгоно. Музейн үзмэр хоёр гол үүргийг гүйцэтгэнэ. Нэгдүгээрт, тухайн түүхэн нөхцлийг ойлгоход туслах үйл явдлын бодит баримт болно. Үзмэр үзсэнээр үзэгч шинэ мэдлэг мэдээлэлтэй болно. Хоёрдугаарт, музейн үзмэрээр дамжуулан үзэгч улс оронд болж буй үйл явдал, эсвэл өнгөрсөн түүхийг мэдэрнэ. Ингэснээр үзэгчийн сэтгэлийг хөдөлгөдөг.

Музейн үзмэр нь хүний хараанд өртөж түүгээрээ дамжуулан тодорхой мэдээллийг хүргэдгээрээ үзүүлэн сурталчилгааны нэг хэлбэр гэж үздэг. Үзүүлэлт түүхэн үйл явцын материаллаг тал, харагдах байдлыг тодотгох, амьдралын нөхцөл, хүмүүсийн дүр төрхийг сэргээн харуулдаг. Музейн үзүүлэлэг бол түүхийн сурах бичиг биш гэдгийг анхаарах хэрэгтэй. Номд түүхэн үйл явцын олон талд гүнзгий анализ хийж, дэлгэрэнгүй бичиж, тухайлбал оюун санааны талыг илэрхийлсэн ойлголт, дүгнэлт хийдэг. Үзүүлэлт байгаа текст бол бодит үзмэрээ дагалдаж явах хэлбэр юм. Үзмэрт тавигдсан ном, гар бичмэл, эд зүйл зэрэг нийгмийн үзэл суртлыг тээж явдаг онцлогтой.

3. Үзүүлэгийн 3 дахь гол зарчим бол хүний сонирхол хэрэгцээнд тохирсон байх зарчим юм.

Энэ нь янз бүрийн нас мэргэжлийн хүмүүст зохицсон, ойлгомжтой, хүлээж авах боломжтой болгох хэрэгтэй. Зарим музей судлаач нар түүхийн үзүүлэлэг нь дундаж хүнд захирагдсан байх ёстой гэдэг. Түүхийн сэдвээр дунд сургуулийн хөтөлбөртэй танилцсан, зохих хэмжээний түүхийн мэдлэгтэй хүн байх ёстой гэж үзэж байна. Үүнээс үүдэн түүхийн музейн үзүүлэгийг хялбарчилсан байдлаар үзүүлж, үйл явцад түлхүү болон онцгойлох хэлбэрийг ашиглахгүй, хэтэрхий нарийвчлахгүй байх, харьцангуй цөөн тооны үзмэр тавих хэрэгтэй гэдэг. Энэ нь түүхэн сэдвийг харуулах нийтлэг хандлага биш. Дундаж үзэгч гэж байхгүй. Тухайн бие хүн өөрийн сонирхол, хүлээж авах чадвараас хамааран түүхийн талаар янз бүрийн мэдлэгтэй байдаг. Иймээс янз бүрийн мэдлэгтэй үзэгчдэд музей зориулагдах ёстой.

Үзмэрийг судалж олон янзаар харуулахдаа гол үзмэрийг онцгойлон харуулна. Эдгээр голлох эсвэл хоёрдугаарт тооцогдох үзмэрт зориулсан тоног төхөөрөмж шаардагдана. Үзүүлэгийн танхимаас гадна гүнзгийрүүлсэн сургалт, үзэгч бие даан судлах зорилготой тусгай танхим музейд байгуулах шаардлагатай гэсэн саналыг зарим судлаачид дэвшүүлдэг. Үзэгчдэд хүргэхийн тулд бичлэг, гэрэл зураг, шинжлэх ухааны хялбаршуулсан үзүүлэн материалууд хэрэглэнэ. Харин хэт задалсан дэлгэрэнгүй хэлбэрээс зайлсхийх хэрэгтэй. Хэсэгчилсэн үзмэрүүд болон танхимуудыг үзэгч хүлээн авах төвлөрөх, авсан мэдлэгээ төсөөлөх, амсхийх нөхцлийг тооцоолох хэрэгтэй.

Эдгээр үндэслэлүүд дээр тулгуурлан байгуулсан музейн үзүүлэлэг аль ч цаг үеийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадна.

Үзүүлэлэгт орчин үеийн хүнийг эртний түүхтэй үзмэрээр дамжуулан

холбож буйг тооцоолох хэрэгтэй. Жишээ нь: археологийн үзмэрт орчин үеийн археологийн судалгааны шинэ мэдээллийг өгөхөөс гадна малтлагын аргыг үзүүлдэг. Дурсамжийн музейд тухайн үйл явдал, хүмүүст орчин үеийн хүмүүс хэрхэн хандаж байгааг үзүүлнэ. Үзүүлэлэгт музей судлалын тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, үзүүлэлэг зохион байгуулалтын шинэ аргуудыг хэрэглэдэг. Музейн судалгааны үр дүн, шинээр цуглуулсан материалыг шуурхай эргэлтэд оруулдаг. Чимэглэх урлагийн шинэ хандлагыг туслах шаардлагатай. Үзэсгэлэнд үзүүлэлэг зохион байгуулалтын онолын хөгжлийг тусгаж, түүхэн сэдэв, уран сайхны чимэглэлийн шийдлийг турших нь илүү зохимжтой. Үүгээрээ байнгын үзүүлэлэгтэй харьцуулбал үзэсгэлэн нь эрэлхийлэх боломж олгодог.

3. ҮЗҮҮЛЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГУУД

Дэлхийн музейн практикт үзүүлэлэг дэглэлтийн арга нь шинжлэх ухааны хөгжилт, түүнд шинжлэх ухаан, соёлын үнэт зүйлсийг түгээгчийх нь хувьд тавигдах шаардлагатай зэрэгцэн үүсэн хөгжиж иржээ. Түүхийн эх сурвалжийг нэгтгэн бүрдүүлдэг учраас үзүүлэл нь тодорхой ангилал шаарддаг. Нэг төрлийн цуглуулгыг чимэглэж дэглэх үзүүлэлэг дэглэлтийн хэлбэр нь шинжлэх ухааны шаардлагыг хангахгүй байлаа. Музейн цуглуулгыг, түүний дотор байгалийн шинжлэх ухааны цуглуулгыг тухайн цуглуулгын ангиллаар дэглэн байрлуулж эхэлсэн бөгөөд энэ ангиллыг боловсруулахад музей оролцож байлаа. Дэглэлтийн энэ аргыг **системчилж үзүүлэх арга** гэж нэрлэсэн. Хэдийгээр түүхийн эх сурвалжийн шинжлэх ухааны ангилал тогтоогүй байсан боловч системчилсэн үзүүлэлэгийн аргыг ерөнхий байдлаар түүхийн үзмэр дээр хэрэглэж байлаа. Эртний археологийн хэсэгт системчлэлийн үндэс нь өнөө хүртэл хадгалагдсан хөдөлмөрийн багаж, зэвсгийн материал юм. (чулуу, хүрэл, төмрийн үе) Үүний дараа үеийн эд зүйлийг материаллаг соёлын төрлөөр нь ангилдаг. Тухайлбал шавар, мод, металл эдлэл, зэвсэг, даавуу, зоос г.м. Угсаатны зүйн музейнүүдэд үзүүлэлэгийн системчлэл нь газарзүйн байрлал ахуйн соёлын байдлаар нь ангилдаг. (тухайлбал: гэр орон сууц хувцас багаж г.м) Ийм үзүүлэлэгт хэв шинжийн ангилал хэрэглэгддэг. Энэ нь тухайн эд зүйлийн хэлбэр, чимэглэлийн хувьслын тухай ойлголт өгдөг гэсэн үг.

XIX зууны II хагасаас түүхийн музейн үзүүлэлэг дэглэлтэд бодит амьдралын нэг хэлбэрийг цогц хэлбэрээр нь тавих арга бий болж эхэлсэн байна. Ялангуяа угсаатны зүйн музейд гэр орон сууц, ажил хөдөлмөр, шашны баяр ёслол зэрэг зан зүйлийг харуулахад илүү дөхөмтэй байв.

Анхандаа ийм бодит амьдралыг дүрсэлсэн цогц үзүүлэлэг нь системчилсэн үзмэрт нэмэлт болгож байснаа XIX зууны сүүлч XX зууны эхээс зөвхөн ийм ансамбль цогцыг байгуулах оролдлогууд хийгдсэн. Эдгээр нь дотор тавилгатай нь нүүлгэн авчирсан тариачдын байшинг барьсан угсаатны зүйн нээлттэй музей байлаа. Түүх-ахуй амьдралыг харуулсан музейд худалдаачид, гар урчуудын хуучин тавилгыг дэглэх болжээ. Ийнхүү үзүүлэлэгийг **цогц хэлбэрээр бодитоор сэргээн харуулах арга** (ансамблевый экспозиционный метод) үүссэн нь ертөнцийг үзэх материалист үзлийн тархалтын хирээр түүхийн шинжлэх ухаанд бий болсон түүхэн ахуйн чиглэлийн нөлөөтэй холбоотой байлаа.

Октябрийн хувьсгалын дараа Орос оронд үзүүлэгийн шинэ аргыг боловсруулсан. Энэ нь хувьсгалт хөдөлгөөний түүхийн үечлэлийн дагуу үзүүлэгүүдийг хэсгүүдэд хуваах, дараа нь сэдэв түүхэн асуудлаар нь сэдэв, дэд сэдэв, цогцолборт хуваах явдал байв. Тавигдсан сэдэвт холбогдох үзүүлэгийн материалуудыг дэс дараалсан, логик холбооны дагуу бий болгосон цогцолборт нэгтгэдэг байна. Энэ цогцолбор нь тавигдсан сэдвийг тодорхой үзэл суртлын үүднээс нээн харуулахын зэрэгцээ бодит байдлын музейн дүр төрхийг бий болгодог байна.

Үзүүлэгт үзэл суртлын агуулга, бүтцийн талаас хандах нь үзмэрийн бүрэлдэхүүнийг ч өөрчлөв. Хэрэв системчилсэн ба цогц хэлбэрээр үзүүлэх аргын үед зөвхөн музейн эд зүйлийг тавьж байсан бол түүхэн үзэгдлийг харуулахын тул бусад сан хөмрөгийн материалын хуулбар, нэгтгэн дүгнэсэн шинжлэх ухааны туслах материал (карт, диаграмм, схем), сэтгэл хөдөлгөх түүхэн уран зураг, уран баримал ашиглах болсон. Бичмэл тайлбарын үүрэг ч өссөн. Анх удаа ерөнхий тайлбар үүссэн. Ерөнхий тайлбарт үзүүлэгийн үзэл суртлын агуулга, үзүүлэгийн цогцолборын нэр, дэс дарааллыг оруулж байв. Үзмэрийн товч тайлбарт ч анхаарах болжээ. Үзүүлэгийн агуулгыг нээхэд уран сайхан чимэглэлийн шийдэл, юуны өмнө үзүүлэгийн зохиомж их үүрэгтэй байв.

Ийм үзүүлэгийг **сэдэвчилсэн иж үзүүлэг** (цогцолбороор үзүүлэх арга комплексно-тематический метод) үзүүлэгийн иж материалуудыг сэдэвчилсэн үзүүлэгийн иж гэж нэрлэсэн. Одоо хүртэл Орос оронд хэрэглэгдэж буй энэ арга мөн гадаад орнуудад ч байна. Гэвч 20-30- аад онд энэ аргыг хэрэглэхдээ бодит үзмэрээр харуулах зарчмыг үгүйсгэж, үзүүлэгийн гол үзмэрт туслах материал, тайлбар, дүрслэн чимэглэсэн үзмэрийг нэгдүгээрт тавьсан.

Өнөө үед энэ алдааг засч хэрэглэхийн зэрэгцээ үзүүлэгийн урьдах аргуудыг ч шинэчилсэн байдлаар хослуулан ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, үзэгчдэд илүү хүрдэг амьдралыг цогц бодитоор тавих арга, материаллаг соёлын хөгжил, тусгай цуглуулгыг харуулах системчилсэн аргыг хэрэглэсээр байна. Үзүүлэгийн цогцолбор бүрийн үндэс болсон музейн эд зүйлийг харуулах арга улам олон төрөл болж байна. Үзүүлэгийн гоо сайхан үзэмжийн асуудалд ч онцгой анхаарал тавьж байна.

Дурсамжийн музей болон музей – дархан цаазат газар олон байгуулагдах болсноор амьдралыг бодитоор цогц харуулах арга их хөгжиж байна. Мөн нээлттэй сан хөмрөг, сан хөмрөгийн үзэсгэлэн ч гаргадаг.

Ийнхүү орчин үеийн музейд үзүүлэг зохион байгуулалтын олон арга хэрэглэгдэж байгаа боловч үндсэн арга нь **сэдэвчилсэн иж үзүүлэг** юм.

4. ТҮҮХИЙН МУЗЕЙН ҮЗҮҮЛЭГИЙН СЭДЭВЧИЛСЭН БҮТЭЦ

Үзүүлэг нь шинжлэх ухааны бүтээлийн адил харилцан уялдаа холбоотой хэсгүүдийн систем юм. Өөрөөр хэлбэл тодорхой сэдэвчилсэн бүтэцтэй байна. Энэ нь үзүүлэгийн нэгдмэл чанар, хэсгүүдийн харилцан холбоо, зохицлыг хангаж, үзүүлэх дарааллыг тогтоодог. Үзүүлэгийн хэсгүүдийн харьцаа, түүнд харуулж буй асуудалд үзүүлэгийн концепци илэрхийлэгдэж байдаг.

Үзүүлэгийн бэлтгэл ажлын нэг чухал хэсэг нь сэдэвчилсэн бүтцийг боловсруулах явдал юм. Түүхийн музей бүр өөрийн онцлог зорилт, цуглуулга, өөрийн орны музейн системд эзлэх байр суурь зэрэгт нийцсэн үзүүлэгийн өвөрмөц бүтэцтэй байна.

Гэвч сэдэвчилсэн бүтцийг тогтоох ерөнхий баримтлал, зарчмыг тэмдэглэж болно. Эрт үеэс өнөө хүртэлх түүхийг харуулсан музейг авч үзье.

Түүхэн зарчмын дагуу сэдэвчилсэн бүтцийг хийхдээ эхлээд нийгэм-эдийн засгийн байгууллаар үндсэн хэсгүүдэд, дараа нь нийгэм-эдийн засгийг хуваах түүхэн үечлэлээр хэсэгт хуваана. Дараа нь сэдэв, дэд сэдвүүдэд хуваана. Сэдэв болон дэд сэдэв нь нэг эсвэл хэд хэдэн үзүүлэгийн цогцолбороос бүрдэнэ. Үзүүлэгийн цогцолбор нь хожим материалыг сонгож авах үед бий болно. Сэдэвчилсэн бүтцийг боловсруулахдаа үзмэрийн танхимын байдлыг харгалзана. Үзмэрийн танхимд үндсэн хэсгийг бүхлээр нь, хэсэг, түүнээс ч бага хэсгийг багтааж болно.

Түүхэн процессыг (үйл явцыг) тусган харуулах музейн хэлбэрийн онцлог нь сэдвийг сонгоход нөлөөлнө. Үзүүлэгийн сэдвийн нэр түүхэн үйл явцын гол чухал талыг тусгасан байхын зэрэгцээ түүнийг музейн эд зүйлээр харуулж болохоор байна. Энэ нь сэдвийн материаллаг тал аль болохоор бүрэн бүтэн тавигдах ёстой гэсэн үг. Ж: нийгэм эдийн засгийн сэдвээр ахуй хэлбэр, үйлдвэрлэлийн арга ажиллагаа, бүтээгдэхүүн, цэргийн түүхийн сэдвээр цэрэг армийн хангамж, бэлтгэл, зэвсэглэл, түүх хувьсгалын сэдвээр хувьсгалт хөдөлгөөний далайц, тэмцлийг харуулна.

Үзүүлэгийн бүтцэд түүхэн зарчмыг хэрэгжүүлэх нь тухайн түүхэн үзэгдлийн шинж чанараас хамаарна. Бүхэлдээ үзмэрт түүхэн үйл явцыг тодорхой цаг хугацаанд түүхэн он дарааллыг баримтлан харуулна. Гэхдээ хэт баримталбал цаг тооллын бичиг шиг дэлгэрэнгүй болж түүхэн зүй тогтлыг илрүүлэх бололцоо олгохгүй тул түүхэн зарчимтай зөрчилдөнө. Тиймээс **“түүхэн он дарааллын зарчим”** гэсэн нэр томъёо гарч ирнэ. Түүхэн үйл явдлыг ач холбогдлоор нь сонгож авахыг хэлнэ. Гэхдээ сэдэвчилсэн бүтцийг зохион байгуулахдаа түүхэн он дарааллын хандлагыг баримтлах нь заавал бус. Энэ арга нь үйл явцлын дэс дараалал чухал үед тохирно. Ж: улс төрийн үйл явдлын өрнөлийг харуулах, хүний намтар, цэрэг түүхийн сэдэвт тохирно.

Харин нийгэм эдийн засгийн сэдэв, соёл, үзэл суртлыг харуулахад дүгнэсэн байдал тохиромжтой. Энд материалыг түүхэн тодорхой үеэр нэгтгэнэ. Гэхдээ нэгтгэгдэж буй үйл явдлын түүхэн он цагийн хязгаар үйл явдлыг хэсэг сэдэв нь хоорондоо давхцахгүй байж болно. Үзүүлэгийг хуваах шалгуур нь үйл явдлын дэс дараалал биш дэвшигдэж буй асуудал. Дэвшигдэж буй асуудал үзүүлэгийн сэдвийн үзэл санааны агуулга, тайлбар зэргээс гарна. Ялангуяа сүүлийн жилүүдэд түүхийн музейд **сэдэвчилсэн бүтцийг асуудал талаас нь** харах нь анхаарлын төвд байна. Асуудлыг дэвшүүлэхэд сэдвийг ойлгох арга зүй, үйл явдалд хандах хандлага тусна.

Үзүүлэгийн бүтцэд зарим үед тухайн харуулж буй хэсгийн он дарааллын хязгаарт багтахгүй сэдвүүд ордог. Ж: ямар нэг орон нутгийн аж үйлдвэрийн хөгжлийг харуулж буй хэсэгт гол үйлдвэрүүдийн зөвхөн одоогийн байдал бус мөн өмнөх түүх, ирээдүйн хөгжил орно. Нэг сэдэвт байдлаар түүхэн намтрыг тодотгож харуулж болно. Түүхэн тодорхой үед үндсэн үйл хэрэг нь өрнөсөн хүний намтрыг бүхэлд нь харуулах. Ийм сэдвийг **хуваахдаа түүхэн он дараалал ба асуудлаар нь харуулах аргын** аль алиныг хэрэглэнэ.

Үзүүлэгийн сэдэв бүрийг тусад нь авч үзэж болно. Гэхдээ эдгээр нь концепцийнхээ хүрээнд харилцан холбоотой. Гол асуудлыг үзүүлэгийн бүх хэсэгт харуулахаас гадна тусгайлан харуулж ч болох юм.

5. ҮЗҮҮЛЛЭГИЙН МАТЕРИАЛУУД

Сэдэвчилсэн бүтэц нь үзүүллэгийн зөвхөн яс мод юм. Түүнийг үзүүллэгийн материалуудын тусламжтай харуулна. Музейн үзүүллэгийг бүрдүүлж байгаа гол материалуудын төрлийг авч үзвэл:

Нэгдүгээрт, **музейн эд зүйл**- түүх соёлын дурсгал, түүхэн эх сурвалж, баримтат гэрэл зураг эдгээр орно.

Хоёрдугаарт, музейн болон бусад дурсгалт зүйлийн **хуулбар**.

Гуравдугаарт, **эрдэм шинжилгээний туслах материалууд**. Энэ нь музейн эд зүйл, түүнд туссан түүхэн үзэгдлийг харагдахуйцаар тайлбарласан байна.

Дөрөвдүгээрт, Бичмэл материал ба дуу бичлэг. Үзмэрийн тухай мэдээлэл өгөх, үзүүллэгийн агуулгыг дэлгэрүүлэн тайлбарласан текст бичмэл материалууд.

Мөн үзүүллэгийн чиглэл хөдөлгөөнийг илтгэн заагч таних тэмдгүүд.

Музейн эд зүйл үзүүллэгийн үндсэн хэсэг болох нь

Үзмэрийг сонгохдоо судалгааны дүнд авсан мэдээлэл, сонирхол татахуйц утга төгөлдөр шинж чанарыг харгалзана. Гэхдээ үзүүллэгийн шаардлага, зорилт, сэдвээс хамаардаг.

Музейн эд зүйл бодит материал

Үзэгчдэд бодит зүйлийн үзүүлэх нөлөө нь хүний ур ухаан гараар бүтсэнд оршино. Материаллаг соёлын эдгээр бүтээгдэхүүнээр дамжуулан хөдөлмөрийг хүндэтгэх, түүнийг бүтээгч хүмүүс, ард түмнээр бахархах сэтгэлийг төрүүлдэг байна. Зарим талаараа бодит материал нь гурван хэмжээст орон зайг эзэлдэг учраас хүлээж авахад хялбар тул үзэгчдийн сонирхлыг ихэд татдаг. Үзэгчдэд нөлөөлөх гол шалтгаан нь үзэгч өөрийн байнгын мэдлэгт түшиглэн үзүүллэгийн арга хэрэгслийн тусламжтайгаар тухайн үзмэрээс төрөл бүрийн мэдээлэл авдаг явдал юм. Эд зүйл нь өнгөрсөн бодит байдлын ул мөрийн хувьд түүний дүр төрхийг бий болгож, баталгаажуулж, тэр үйл явдалтай холбоотой болохыг үзэгчдэд ойлгуулдаг. Гэхдээ бодит материалын гоо зүйн ач холбогдлыг мартаж болохгүй.

Үзүүлэлт юуны өмнө гадна талаасаа анхаарал татах шинж тэмдэг, тамга, тэмдэглэл, хурц тод хийц, үйл явдлын ул мөр бүхий үзмэрийг сонгоно. Эдгээр шинж тэмдгийг хүнд анзаарагдахаар болгохын тул олон арга хэрэглэнэ. Үүнд: Эргэдэг хавтан хийх, толиор фон болгох, зоос, гоёл чимэглэл зэрэг жижиг зүйлийг томруулж харуулах, тусгай суурь тавих зэргээр. Эрдэм шинжилгээний ажилтан энэ мэтчилэнгийн аргыг санал болгож болно. Гэхдээ эд зүйлийн агуулга, утга учрыг үгээр тайлбарлах, заримдаа тодорхой зураг, схем зэргээр харуулах хэрэг гарна.

Дурсгалт эд зүйл нь үзүүлэлт онцгой байр суурьтай. Юуны түрүүн түүхт хүний үйл ажиллагааг харуулсан эд зүйл - жанжин хувцас, хөдөлмөрийн баатрын ажлын хувцас, хөдөлмөрийн багаж эрдэмтний туршилтын багаж, зохиолчийн үзэг г.м. Хувийн эд зүйлс ном, бичиг баримт нь тухайн хүнийхээ давтагдашгүй байдлыг илэрхийлнэ. Мөн тодорхой үйл явдалтай холбоотой туг, далбаа, трактор (атрын анхны) зэрэг дурсгалын эд зүйл.

Дурсгалын зүйлийг дэглэхдээ түүнд хандах хандлагыг тусгасан дэглэлтийн арга (том орон зай, заримдаа тусгай гэрэлтүүлэг, хүрээ, тавиур, дуу чимээ) хэрэглэнэ. Тухайн үйл явдлыг мэдрэх орчинг бий болгох хэрэгтэй. Эдгээр эд зүйлс гадаад байдлаараа ижил эд зүйлээсээ ялгагдахгүй тул

тайлбарыг дэлгэрэнгүй өгнө. Түүхэн үйл явдлыг (хурал, тэмдэглэлт ой, төрийн айлчлал) түүнд зориулсан бэлэг дурсгалын зүйлийн хамт тавьдаг.

Дүрслэх урлагийн бүтээл

Үзүүлэлт дүрслэх урлагийн бүх бүтээлүүд ашиглагдана. Дүрслэх урлагийн бүтээлүүдэд гэрэл зургийн адил нийгмийн амьдралын янз бүрийн тал тусдаг тул үй явдлын орчин тойрныг үзэгчдэд ойлгуулж, түүхэн үйл явцыг тодорхой болгож, бие хүнтэй холбож амьдруулдаг. Дүрслэлийн уран чадвараас гадна баримт нотолгоо болж чадах эсэхийг харна. Түүнээс гадна дүрслэх урлагийн бүтээлд зохиогчийн үзэл санаа тусдаг. Ялангуяа зураачийн үзэл санаа, нийгмийн гарал шог зураг, зурагт хуудаст хурц тусдаг тул тухайн үеэ илэрхийлнэ. Дүрслэх урлагийн бүтээлийг бүтээгдсэн он цаг үетэй нь холбож, байрлуулахдаа он цагийг бичнэ.

Мөн түүхийн сэдвээр диорам хэрэглэнэ. Диорамыг уран зургийн фоны өмнө бодит үзмэр тавьж, гэрэлтүүлгийн аргаар дүрслэлийн өвөрмөц орон зайг бий болгож хийдэг. Үзэгчдийг түүхийн сэдвийн ижил давтамжаар уйдааж эцээхгүйн тулд үзүүлэлийн нэг гол оргил хэсэг болгон диорамыг ашигладаг. Гэхдээ диорамыг зөвхөн онцгой үйл явдлыг харуулахад л хэрэглэхээс гадна газар нутгийн байр зүйн зураг, барилга байгууламжийг харуулахад тохиромжтой.

Гэрэл зургийг сонгохдоо авагдсан нөхцөл, зорилгыг тогтоохоос гадна, заримдаа бусад материалаас баримтат чанарыг шалгана. Болбол зохиогчийг ч тодруулах хэрэгтэй.

Гэрэл зургийг дэлгэхдээ янз бүрийн арга хэрэглэнэ. Чухал бөгөөд заримдаа шийдвэрлэх шалгуур нь зургийн чанар юм. Гэхдээ дурсгалт ховор гэрэл зургийг тавина. Хадгалалтаас нь шалтгаалан янз бүрийн чанартай байдаг учир чимэглэлийн хүрээг маш сайн хийх ёстой. Гэрэл зургуудыг тойруулж хэсэгчлэн авах, монтажлах зэрэг олон аргаар тавьж болно. Байнгын үзүүлэлт фотомонтаж хийхийг зөвлөдөггүй.

Танин мэдэхүйн материалын нэг нь кино, диапозитив юм. Баримтат киноны сэдвийг хэсэгчлэн үзүүлэх бөгөөд үзэгч хүсвэл бүтнээр нь үзэх боломжийг музейн бэлдсэн танхимд олгоно. Эдгээр дүрслэл хурдан солигддог тул байнгын үзүүлэлт хязгаарлагдмал хэрэглэнэ. Мөн үзүүлэлт газрын зураг, дулхийн бөмбөрцөгийн дүрс глобус, план зургийг хэрэглэнэ.

Баримт бичиг

Агуулга, хадгалагдах чанараараа баримт бичиг эх сурвалж маш чухал үүрэгтэй. Баримт бичгийн агуулгыг үзэгч уншиж ойлгон хүлээж авахад хүндрэлтэй тул юуны өмнө цаг үеийнхээ дурсгал, нотолгоо болно. Үзэгч баримтын гадаад байдлын онцлог, бичгийн хэв, үсгийн онцлог, чимэглэлийг сонирхдог тул нэр, товч утга зэргийг нь шууд нүдэнд тусахаар тавина. Баримтаа гэмтээхгүйгээр доогуур нь зурах, сумаар заах, ишлэх, гэрэл зургаар зарим хуудсыг тавих, тодруулах зэрэг арга хэрэглэдэг.

Дуу авианы материал

Сэдвийг үнэмшилтэй, анхаарал татахуйц болгохын тулд бодит хүмүүсийн яриа, байгаль амьтан ургамлын дуу авиа шуугиан зэргийг үзүүлэлт хэрэглэдэг. Гэхдээ бусад сэдвийг хэт дарахгүй, бүх үзэгчдийн анхаарлыг сарниулахгүй байх шаардлагатай тул зөвхөн тухайн хэсгийг үзэж буй үзэгчдэд зориулсан аппарат хэрэгслийг ашиглах нь зүйтэй.

Ер нь үзүүлэг бодит зүйлийг харуулдаг боловч тодорхой зорилготой дэлгэх нь цуглуулгын ашиглалтыг сайжруулах, танин мэдэхүйн ач холбогдлыг өргөтгөх ач холбогдолтой.

Хуулбар дараах тохиолдолд хийгдэнэ.

- Эд зүйлийг гэмтээхгүйн үүднээс хийдэг бөгөөд тайлбарт эх нь хаана байгааг заадаг.
- Музейн гадна байгаа зүйлийн (үл хөдлөх, том хэмжээтэй)
- Эд зүйлийг хадгалагдаж үлдсэн хэсгийг ашиглан сэргээх
- Баримт бичиг, дүрслэх урлагийн материалын хуулбар. Гэхдээ хэт их хэрэглэхгүй байх.

Голдуу механикаар хуулбарлаж болох зүйлийн хуулбар хийнэ. Ж:

дурсгалт зүйл нь ганц хувь байдаг тул түүний хуулбарыг бараг хийж тавьдаггүй. Цөөн тохиолдолд хийдэг боловч дурсгалт чанараа алддаг байна.

Эрдэм шинжилгээний туслах материал

Үзмэрийн танин мэдэхүйн ач холбогдлыг дээшлүүлэх үүднээс

ашиглана. Эдгээрийн тусламжтай газар зүйн байрлал (газрын зураг), тооны харьцуулалт (диаграмм), харилцан холбоог (схем) харуулна. Үзэгч нэгтгэж дүгнэсэн байдлаар нь хурдан хүлээж авдаг. Түүхийн музейд нийгэм-эдийн засгийн, угсаатны зүйн, улс төрийн гэх зэрэг олон картыг тавьдаг. Диаграмм хөгжлийн харьцааг харуулдаг тул эдийн засаг, соёлын хөгжлийг харуулахад ашиглана. Харин төрийн зохион байгуулалт, үйлдвэрлэлийн явцыг схемээр үзүүлдэг. Мөн тоон таблиц ч хэрэглэж болно. Гэхдээ эдгээрийг бага хэрэглэж, туслах материал болохыг байр, зохиомж, харагдах байдлаар үзүүлдэг.

Тайлбар ба дуу бичлэг

Үзэгч бүр үзмэрийн тухай мэдээлэл, концепцийг хараад шууд

ойлгож чадахгүй тул хэд хэдэн төрлийн тайлбар тавина.

Нэгтгэсэн тайлбарууд:

1. Голлох (ерөнхий) тайлбар- Үзэгчийн анхаарлыг татах зорилготой бөгөөд концепцийг агуулна.
2. Танхим, хэсэг, сэдвийн гарчиг нэр - Үзүүлэгийн сэдэвчилсэн бүтцийг харуулдаг. Үзэгч үзмэрийн зохион байгуулалтыг ойлгож, маршрутаа тогтооход нь туслана.
3. Тайлбар текст - танхимын гол агуулгыг бичнэ. Үзмэрийн түүх, хамгийн сонирхолтой материал, үзэх дэс дарааллыг бичиж болно.
4. Хаяг тайлбар: Үзмэр нэг бүрийн тайлбар. Энэ нь дансан дахь нэрийн

давталт бус. Хэрэв үзмэрийн хийгдсэн материал чухал бол заана, хэнийх болон хийсэн хүн нь чухал бол бичнэ. Дүрслэх урлагийн бүтээлийн нэр нь гарчиг болно. Харин урлагийн музейд зураач нь чухал. Үзүүлэгт яагаад тавьсан шалтгааныг тодруулах мэдээлэл, хийгдсэн хугацаа ба зохиогч, үйлдвэрийн марк, материал, хийгдсэн газар болон аргыг бичнэ. Дараа нь

агуулгаас нь хамааруулан нэмэлт болгож хэрэглэх арга, эд анги, хийсэн ба хэрэглэж байсан түүх, заримдаа хэрхэн музей олж авсан, түүхэн үйл явдалтай хэрхэн холбогдох тухай мэдээлэл өгдөг. Бичиг баримт, ном дурсгалт үзмэрийн тайлбарт агуулгыг маш товч бичдэг байна.

Сүүлийн үеийн социологийн судалгаанаас үзэхэд үзэгч дэлгэрэнгүй мэдээлэл хүсдэг байна. Харин үзмэрт өөр дээр нь байгаа мэдээллийг давтдаггүй. Ж: сонины нэр. Үзүүлэгийн танхимд тайлбарыг уншихад хэцүү байдаг тул цөөн үгээр, тодорхой, агуулгатайгаа тохирсон байхаар бичдэг.

Голлох тайлбарыг нийтэд нь тусгай шрифтээр бичихдээ утгаар нь таслах бөгөөд онцгой тохиолдолд таслал хийнэ. Шрифтийн янз бүрийн хэлбэрийг хэрэглэхдээ үсгийн эртний хэлбэрийг хэрэглэхгүй. Хаяг тайлбарын төрөл бүрийн мэдээллийг бичихдээ янз бүрийн шрифт, өнгийн фон хэрэглэх зэрэг арга хэрэглэнэ. Нэг төрлийн олон зүйлийг дэлгэхдээ дэс дугаарлаж, тайлбарыг тусад нь бичнэ. Мөн харааны түвшнээс дээр тавигдсан үзмэрийг ингэнэ. Энэ тохиолдолд, үзмэрийн схемчилсэн план зурагт (доор байрлуулсан) энэ тухай заана. Групп үзэгчдэд тайлбарыг бичлэгээр сонсгох нь улам түгээмэл болж байна. Үзэгч бүрт үзмэрийн талаар чиглэл өгөх мэдээлэлтэй жижиг магнитофон өгнө.

Заагч таних тэмдгүүд

Үзэгчдийн ихэнх нь тайлбарлагчгүй үздэг тул тэднийг хөнгөвчлөхийн тул үзүүлэгийн үүдний танхимд танхимуудын план зургийг нэртэй, заримдаа танхим бүрийн бэлэгдэлтэй байрлуулдаг. Танхимуудын зургийг янз бүрийн өнгөөр будаж, хамгийн сонирхолтой үзмэр, амралтын хэсгийг онцлон тэмдэглэнэ. Танхим бүрийн өмнө план зураг, ерөнхий маршрут, үзүүлэгийн сэдэв (цогцолбор) нэр дэс дугаарыг тавьдаг. Танхимд хана болон газарт сумаар зааж болно.

6. МУЗЕЙН ҮЗҮҮЛЛЭГИЙН ЦОГЦОЛБОРУУД

Музейн эд зүйл ба үзүүлэгийн бусад материалуудыг бүтцийн сэдвийн дагуу үзүүлэгийн цогцолборуудад нэгтгэдэг. Цогцолборын систем нь түүхэн үйл явц, бодит байдлыг тусгадаг.

Музейн үзүүлэгийг байгуулахад “музейн шинж чанартай” болгох бүтээлч ажиллагаа, хийсвэр ойлголтыг тодорхой зүйлээр харуулах, өнгөрсөн өнөө үеийн “музейн дүр төрхийг” бий болгох чадвар биеллээ олдог. Заримдаа “үзүүлэгийн цогцолбор” гэдэг нэр томъёог **бүхэл бүтэн танхимын** тухай ярихад хэрэглэдэг. Үчир нь үзмэрийн танхимыг үзэгч нэг бүхэл зүйл гэж ойлгодог байна. Эхлээд үзмэрийн танхимыг “доминант”-ыг тодорхойлогчыг сонгоно. Энэ нь гол үзэл санаа ба нүдэнд харагдахуйцаар илэрсэн ноён нуруу, сэдэв, илүү сэтгэл татахуйц цогцолбор буюу саланги үзмэрүүд юм. Нэг үгээр хэлбэл үзмэрийн нүүр царайг бий болгодог, анхны сэтгэгдэл төрүүлдэг бүх зүйлийг тодорхойлж, үзмэрийн **дарааллыг** төлөвлөнө.

Танхимыг төлөвлөхөд орон зайн нарийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай тул зураач дизайнер нилээд, цөөн бус тохиолдолд удирдах үүрэгтэй. Ихэнхдээ энэ ойлголт **танхимын доторх цогцолборт** хамаарна. Сэдэвчилсэн үзүүлэгт цогцолбор гол юм. Цогцолборт үзүүлэгийн ерөнхий бүтцийг бүрдүүлж буй сэдэв, дэд сэдвийн утга зүй (логик), **утга санааны агуулгыг илэрхийлэх үүднээс музейн эд зүйл ба туслах материалуудыг нэгтгэдэг.**

Ийм цогцолборт бий болгосон дүр төрх нь бодит амьдралд байсантайгаа яг адилгүй. Түүхэн бодит байдлыг үзүүллэгийн шинжлэх ухааны концепци, сурган хүмүүжүүлэх, сурталчилгааны зорилтын дагуу баримтжуулан тайлбарлана.

Сэдэвчилсэн үзүүллэгийн цогцолборуудад янз бүрийн далайц, шинж чанартай үзэгдлүүдийг харуулдаг учраас тэдгээр нь өвөрмөц ялгаатай байдаг. Мөн музейн цуглуулга нь хамаарна. Цогцолбор бүрийг сэдвийн хувьд холбоотой бусад цогцолборуудаас салгах аргагүй. Тиймээс зөвхөн цогцолборуудыг байгуулахад баримтлах хандлага, амьдралаар шалгагдсан аргуудын талаар ярья.

1-рт, үзүүллэгийн сэдэвчилсэн цогцолборт үйл явдал буюу үзэгдлийн талаарх бидний мэдлэгийн эх сурвалж болох музейн эд зүйлийг нэгтгэдэг. Гэхдээ судлаачийн ашигласан бүх сурвалжийг танхимд тавихгүй. Зөвхөн **түүхэн бодит байдлын чухал шинж чанарыг илүү хүртээмжтэй, нэгтгэсэн байдлаар илэрхийлж чадах эх сурвалжийг сонгоно**. Үзэгч үзүүллэгээс мэдлэгийг “олж авахгүй”, харин “авдаг” боловч шинжлэх ухааны эрэл хийх боломжтой байдаг. Үзэгч эх сурвалжуудыг үзэхдээ судалгааны замыг товчилж янз бүрийн арга замаар үзүүлэлт харуулж буй дүгнэлтэд хүрдэг.

2-рт, үзүүллэгийн цогцолборт түүхийн судалгаанд голдуу ашиглагддаггүй боловч амьдралын үзэгдлийн талаар **нүдэнд харагдахаар ойлголт өгдөг материалуудыг** оруулдаг. Музейн үзэгчийг орон зай цаг хугацааны хувьд биднээс алслагдсан объектоор аялахыг урьдаг – үйлдвэрээр “аялах”, тулалдааны талбарт “очих”, номноос гардаг түүхэн бие хүн, дуртай номныхоо анхны хэвлэлийг “харах” зэрэг бололцоог олгодог. Амьдралд энэ 2 хандлага нь харилцан холбоотой бөгөөд үзмэрийг сонгож авах үндэслэл болдог.

Цогцолборт амьдралын үзэгдлийг олон талаас нь харуулахдаа ихэвчлэн музейн эд зүйлийн янз бүрийн төрлийг багтаадаг. Аль нь давамгайлах нвь сэдэв болон музейн цуглуулгаас шалтгаална. Ж: нийгэм-эдийн засгийн үзэгдэл, ард түмний ахуй нь биет ул төрийг хамгийн их үлдээдэг. Харин үзэл суртлын асуудал юуны өмнө баримт бичигт тусдаг байна.

Хэрэв цогцолбор нь үзүүллэгийн сэдвийн нэг хэсэг бол нэг төрлийн материалаас бүрдэж болно. Тухайлбал, улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийг харуулахад хөдөлмөрийн багаж, ахуй эд зүйлс, бичмэл болон дүрслэх урлагийн бүтээлийг тусгай цогцолбор болгож болдог байна. Тэдгээр нь бүхэлдээ сэдвийн агуулгыг гаргаж чадна.

Цогцолборт орж буй музейн эд зүйл нь зөхөн хэлбэрийн хувьд нэг төрлийн биш. Сэдэвт хамаарч буй эд зүйлийн дотор тухайн үйл явдал үзэгдлийн дунд бий болсон ба гарал үүслээрээ холбогдолтой боловч, илүү тод харуулах үүднээс татан оруулж буй эд зүйлүүд байдаг. Энэ нь үзүүллэгийн сэдэвчилсэн **цогцолборыг зохиох боловч зохиомжийг хийх үндсэн аргатөв буюу голлох үзмэрийг онцлох нэг шалгуур болдог**.

Ач холбогдол ба сэтгэл татах чадвараа онцгой чухал музейн эд үзмэрийг бие даасан нэгж үзмэр болгож болно. Гэхдээ энэ цогцолбортойгоо агуулгаараа холбоотой байдаг.

Үзмэр хоорондын харилцан холбоог харуулах арга нь үзүүллэгийн үнэмшилтэй байдлын дээшлүүлнэ. Энэ холбоо нь хамгийн энгийн байж болно. Ж: хэвлэлийн машиныг түүн дээр хэвлэсэн зүйл, үсгийн хэв зэрэгтэй нь тавих.

Харин янз бүрийн эд зүйлийг “харилцан баримтжуулах” нь илүү хэцүү. Түүний гадаад талын адил байдалд тулгуурлан хийж болно: хөрөг зураг дахь хүний хувцсыг бодит хувцастай, цехэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний гэрэл

зургийг нэг бүтээгдэхүүнтэй нь том хэмжээний техникийг түүний нэг детальтай нь, тавилгыг өрөөнд тавигдсан байдлынх нь зурагтай гэх мэтээр тавина.

Ийнхүү харилцан баримтжуулж гадна талаасаа харагдахгүй холбоог харуулж болдог. Жишээлбэл: шилмэл сортын буудай гаргаж буй эрдэмтний гэрэл зургийг тэр буудайн жишээ ба энэ бүтээлийнхээ төлөө авсан шагналын нь хамт тавьдаг.

Үзэгч ойлгоход хүндрэлтэй баримт бичгийг “**бодитой болгох арга**”-ыг хэрэглэн харилцан баримтжуулна. Эдгээр баримт бичигт түүнээс өөр ямар ч “ул мөр” үлдээгүй боловч түүхэн чухал ач холбогдолтой үйл явдлын тухай мэдээ үлдсэн байх тохиолдолд баримтад дурдагдсан цаг хугацаа, утгаараа тохирч биет үзмэр ба дүрслэх урлагийн бүтээлийг дагалдуулан дэглэдэг. Жишээ нь: тариачны бослогын тухай баримт бичгийг түүнд өгүүлэгдэж буй зүйлс-тэр нутгийн тариачны дүр, бослого гарсан газрын дүрслэл, зэвсэгтэй хамт тавьдаг.

Эд зүйл, түүний хэсгийг **харьцуулах** боломж олгох аргыг хэрэглэснээр /дайнд сүйдсэн гудамж талбайн гэрэл зургийг сэргээн босгосны дараах байдалтай нь харуулах, үндэстэн ястны соёлын харилцан нөлөөллийг хувцасны жишээн дээр харьцуулах/

Барилга барих үйл явцыг харуулсан гэрэл зураг, автомашины моделиуд нь барилга байгуулалт, үйлдвэрлэлийн хөгжлийн талаар ойлголт өгнө. Жишиж харуулах нэг арга нь эсрэг тэсрэг зүйлсийг зэрэгцүүлэн тавих явдал юм.

Үйл явдлын далайцыг онцлон үзүүлж, сэтгэгдэл төрүүлэхийн тулд нэг төрлийн материалыг олноор нь нэг дор тавьдаг-дэлгэж тавьсан толгой даавуунууд, буу зэвсгийн цуглуулга, олзлогдсон буу зэвсэг гэх зэрэг.

Цогцолборт шинжлэх ухааны туслах материал болон голдуу танхим сэдэвт бүхэл нь хамаарах голлох ерөнхий тайлбарыг заримдаа оруулдаг.

Эдгээр аргыг хэрэглэхдээ үзмэрийн шинж чанарыг харгалзах хэрэгтэй. Жишээ нь: эзлэн түрэмгийлэх ба шударга дайныг адилхан тавихгүй.

Дахин сануулахад тайлбарт туссан зохиогчийн үзэл санаа, үзэгчдэд шууд нөлөөлдөг эд зүйлийн өгөх ойлголт нэгдмэл байх ёстой. Ийм алдаа нилээн их тохиолддог нь материалаа шилж аваагүйгээс болдог байна. Үзүүлэлт дэвшигдсэн сэдвийн үйл санааны агуулга тусгалаа олдог тул үзмэрийг байрлуулах, дэглэх ажлаас эрдэм шинжилгээний ажилтан үзмэр дэглэгч хөндий байж болохгүй. Музейн онцлог ба сэдвээс хамаарч тэгш хэмээр юм уу, чөлөөтэй, хэд хэдэн үзмэрийг цуг буюу ганцаарчлан харуулах, голлох үзмэр, хоёрдугаарт болон далд тавих, туслах материалыг хаана байрлуулах зэрэг асуудлыг шийдвэрлэдэг. Зураач-дизайнер зөвхөн үзүүлэлт дэглэгчийн саналд тулгуурлан хамгийн оновчтой шийдвэр гаргана.

Өнөө үед сэдэвчилсэн үзүүлэлт амьдралын иж цогц үзүүлэгийг их хэрэглэж байна. Голдуу дотоод тавилга, түүний хэсэг байдаг. Энэ хэлбэрийн үзүүлэлт 2 төрөл байдаг. Үүнд: амьдралаас авсан жинхэнэ биет ба музейн үзмэр, зураглал, гэрэл зураг, хэмжээ зэрэг бусад эх сурвалжийг ашиглан сэргээн хийсэн.

Комплекс-ансамблийн нэг онцгой хэлбэр нь өрж тавьсан үзмэр юм. /дүрс, баримал/ тэдгээрийг антропологийн хэв шинж, хөдөлмөрийн үйл явц, зан үйлийн онцлогийг харуулахад хэрэглэхэд тохиромжтой. Голдуу угсаатны зүйн үзүүлэлт байдаг.

Комплекс-ансамбль нь үзэгч тусгай харах байрнаас гаднаас нь хардаг буюу дотуур нь явж орчинд нь ордог тусгай танхим байж болно. Түүний тайлбар нэр, ерөнхий тодорхойлолт ба зарим нэг эд зүйлийн талаарх шаардлагатай

мэдээллээс бүрдэнэ. Мөн план зурагт дурсгалт ба ердийн, жинхэнэ эх, хуулбар зэргийг томьёолсон тэмдгээр тэмдэглэнэ.

Комплекс-ансамбль нь бодит амьдралтай төстэй байдал бий болгосноор сэдэвчилсэн үзүүлэлт нэмэлт болж, амьдруулж, үзэгчийг түр амраадаг.

Сэдэвчилсэн үзүүлэлт багтдаг **нэг төрлийн цуглуулга** нь сэдэвт хамаарна. Жишээ нь: XVI-XVII зууны зоосны цуглуулга, худалдааны харилцааг, эрүүлийн цуглуулга, гар урлалын бүтээгдэхүүний хувьд нутгийн өвөрмөц байдал, давхцсан байдлыг харуулна. Мөн цуглуулгын цогцолбор нь сэдэвчилсэн үзүүлэлтийн эх сурвалж болж чадах чадварыг дээшлүүлнэ.

Сэдэвчилсэн үзүүлэлт цуглуулгын цогцолборыг оруулах нь материаллаг эд зүйлийг салбараар, баримт бичгийг төрлөөр нь системчилж тавих болоцоог үгүйсгэхгүй.

Түүнчлэн үзүүлэлтийн танхимд цогцолбор бүрдээ тус тусад нь бус харин түүхэн агуулгатай бүхэлд нь холбоотой үзмэрийг тавьж болно. Энэ нь мебель, толь, чимэглэлийн сийлбэр зэрэг чимэглэлийн гар урлалын эд зүйл, гэрэлтүүлэг юм. Эдгээр нь тухайн үеийн материаллаг соёлыг харуулж танхимын дүр төрхийг бий болгодог байна.

Үзүүлэлт дэглэн байгуулах ажил.

Эрдэм шинжилгээний төлөвлөлт

Музейн үзүүлэлтийн зохион байгуулах нь маш төвөгтэй нарийн зүйл юм. Үзүүлэлт үзэсгэлэн зохион байгуулалтын ажил нь музейн үйл ажиллагааны төлөвлөлтийн чухал хэсэг байдаг.

Үзүүлэлтийн бэлтгэх нь ажил нь төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэх гэсэн хоёр дамжилгаас бүрдэнэ. Үзүүлэлтийн төлөвлөгөө нь эрдэм шинжилгээний, уран сайхны, техник хэрэгсэл ажлын гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.

Төлөвлөлттэй зэрэгцэн үзүүлэлтийг сурталчлах ажил явагдана.

Үзүүлэлтийг байгуулахад хэд хэдэн нөхцөл шаардагдана.

Үүнд: 1-т Үзүүлэлтийн сэдвээр цуглуулгатай байх. Гэхдээ шаардлагатай бол нэмж цуглуулж болно. 2-т үзүүлэлтийн арга зүйг эзэмшсэн, сэдвийн асуудлыг мэддэг бүтээлч хамт олон, 3-т үзүүлэлт зохицсон байр, тоног төхөөрөмж, хөрөнгө зэрэг орно. Танхимын талбай хэмжээ шинж чанар нь сэдэв, бүтэц, аргад нөлөөлнө.

Төлөвлөлтийн явцад үзүүлэлтийн агуулгыг хөгжүүлж, нарийвчилсан эхэд хэдэн баримт бичиг боловсруулдаг. Эдгээр бичиг баримт боловсруулагддаг. Эдгээр бичиг баримт нь архитектур-уран сайхны төслийг боловсруулах үндэс болно.

Үзүүлэлтийг хийж эхлэх нь түүхэн судалгааны эхний шатны ажилтай адилхан. Сэдвийн талаарх ерөнхий болон тусгайлсан судалгааны ажлуудтай танилцана. Судалгааны зохиолоос тэмдэглэл хөтлөхдөө сэдвийг биет зүйлээр харуулах боломжийг олно. Судлаачдын зөвлөлгөө нь ялангуяа орчин үеийн түүхийг харуулахад чухал. Түүнчлэн сэдвийн талаарх эх сурвалжийг хайхдаа юуны өмнө өөрийн музейд болон бусад музей архив номын санд байгаа материалтай танилцах хэрэгтэй.

1. Шат. Үзүүлэлтийн концепц үндсэн чиглэл боловсруулна. Концепци нь

Үзүүлэлтийн зорилтыг (экспозиционный замысел) боловсруулах суурь болно. Концепци нь байгуулах үзүүлэлтийн анхны хамгийн ерөнхий төлөөлөл юм. Концепцид үзүүлэлтийн агуулга, архитектур-уран сайхны шийдэлтэд тавигдах шаардлагууд тусгагдана. Сэдвийн судлагдсан байдал, урьд байсан ба бусад

музейд буй үзүүлэгээс ялгагдах байдал, онцлогийг бичнэ. Концепцид үндсэн үзэл санаа, зангилаа асуудлууд, гэгээрэл боловсролын ажлын боломжийг бичнэ.

Агуулгыг бичихдээ сэдвийн бүтцийн үндэслэл, гол бүрэлдэхүүн хэсэг, тавигдах шаардлагатай үзмэр эд зүйл, музейн цуглуулгад буй эсэхийг тодруулна. Ингэхдээ нэмэлт цуглуулга хийх зүйлийн жагсаалт гаргана. Үзүүлэх аргыг бичнэ. “(сэдэвчилсэн үзүүлэгийн цогцолборт тавих, бодит байдлыг сэргээн харуулах, цуглуулгаар тавихын аль нь болох)

Үзүүлэгийн талбайн ерөнхий план зургийг (байрлал) хавсаргахаас гадна танхимуудад хэсэгчлэн хуваарилсан зургийг хавсаргаж болно. Мөн үзэл баримтлалыг илэрхийлж буй гол үзмэр юмуу цогцолбор, анхаарал татах үзмэрүүдийг (диорам, интерьер, дурсгалт комплекс, онцгой том үзмэр) оруулна. Өөрөөр хэлбэл үзүүлэг хэрхэн харагдах байдлын талаар ойлголт өгнө. Мөн зарим холбогдох үзмэрийг музейн үүд болон эргэн тойрон байрлуулах талаар саналаа бичиж болно.

-концепци нь дараагийн баримт бичгийг боловсруулахад суурь болдог. Сэдэвчилсэн бүтцийн үндэслэл ба бүрэлдэхүүн гол хэсгүүдийг тодорхойлох нь Товч сэдэвчилсэн бүтэц (ТСБ), дараа дэлгэрэнгүй сэдэвчилсэн бүтцийг (ДСБ) бий болгох боломж олгоно.

-Эх сурвалж, материалыг тодруулснаар үзмэрийн жагсаалт гаргаж болно. Эд зүйлийн жагсаалтыг эцсийн баримт бичиг үзүүлэгийн сэдэвчилсэн төлөвлөгөөнд (ҮСТ) оруулна.

-Архитектур –уран сайхны шийдэлтэд (АУСШ) тавигдах анхны шаардлагуудыг зураач-дизайнер бүтээлчээр хөгжүүлнэ. Төлөвлөлтийн эдгээр анхан шатны асуудлуудад онцгой анхаарах шаардлагатай.

-Төлөвлөлтийн дараагийн үе шатууд АУСШ-тэй холбоотой явагддаг.

II. Сэдэвчилсэн бүтэц.

Музейн үзүүлэгийн зорилтыг хэрэгжүүлэхэд сэдэвчилсэн бүтэц чухал болохыг бид тайлбарласан. Сэдэвчилсэн бүтцийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийн нарийвчлэн сэдвүүдэд хуваахдаа дахин ном зохиол, эх сурвалж, музейн сан хөмрөгийг судлах шаардлагатай болно. Сэдэвчилсэн бүтцийг тодорхойлох нь музейн үзүүлэгийн онцлогт тохирсон сэдэв сонгоход чухал. Үзүүлэгийн сэдэвчилсэн бүтцийг судлагааны номын сэдэвчилсэн бүтэцтэй адил хийхээс зайлсхийхийн тулд энэ нарийн ажлыг гүйцэтгэнэ.

Музейн өдөр тутмын практикт үзүүлэгийн шинжлэх ухааны үндэс, зорилт сэдэвчилсэн бүтцийг товчлон “үзүүлэгийн шинжлэх ухааны концепци” гэж нэрлэнэ.

Сэдэвчилсэн бүтцийг дэд сэдвүүд, жижиг сэдвүүд, цогцолборт хувааснаар сэдэвчилсэн дэлгэрэнгүй бүтэц бий болно. Энэ ажил нь сан хөмрөгт эд зүйлийг сонгох, нэмж цуглуулах төлөвлөгөө гаргах ажилтай зэрэгцэн явагдана.

Сэдэвчилсэн төлөвлөгөө

Концепци, дэлгэрэнгүй сэдэвчилсэн бүтэц нь сэдэв бүрийн утга санааг харуулж чадахгүй тул (ялангуяа ном зохиолд тусгагдаагүй сэдвийн үед) ихэнх музей дэлгэрэнгүй сэдэвчилсэн бүтцийг сэдэвчилсэн төлөвлөгөө болгодог.

Сэдэвчилсэн төлөвлөгөөг дараах байдлаар хийнэ.

Музейн нэр

Танхимын нэр

Зохиогч он сар өдөр

Сэдэвчилсэн бүтэц

Хэсэг бүрийн утга санааг бичих болбол ерөнхий тайлбарын нэр, ашигласан ном тавихаар төлөвлөсөн үзмэрийн нэгтгэсэн жагсаалт, товч шинж чанар цуглуулга хийх шаардлага, зүйл арга (хээрийн хайгуул, бусад)

ДСБ-г хийхийн зэрэгцээ сан хөмрөгийн цуглуулгатай танилцан сонгох, үзмэр цуглуулах ажилд орно.

Цуглуулсан материалын тухай мэдээллийг картад бичнэ. Эд зүйлийн нэр, дансны номер буюу музейгээс бусад газрын нэр, ямар сэдэвт холбогдох тухай бичнэ. Ингээд картын каталогтой болно. Каталогт картын хэсэг, сэдэв, дэд сэдвээр байрлуулна. Энэ каталог нь бэлтгэгдэж буй үзүүлэгээс гадна татан буулгах үед ч үнэлж баршгүй мэдээлэл болно. Түүнийг хаяг тайлбар, тайлбартай аялал, давтлага, зураач дизайнертай хамтран ажиллахдаа хэрэглэнэ.

III. үзмэр шилэн сонгох

Сонгосон бүх материал үзмэрт тавигдахгүй тул дараагийн үе шат үзмэрийг шилэх ажилд ордог. Сонгосон материалаас концепцийг илэрхийлж чадах, онцгой чухал мэдээлэлтэй түүхэн үйл явдлыг төлөөлж чадах, гадаад үзэмж, гоо сайхан, урлагийн бүтээл, сэтгэл татахуйц эд зүйлийг шилнэ. Чухам энэ ажлын үед үзүүлэгийн сэдэв, дэд сэдвийн хүрээн дэх сэдэвчилсэн үзүүлэгийн цогцолбор бий болно. Үзмэр шилэх, цогцолбор бий болгох гэсэн 2 ажил нь харилцан уялдаатай. Нэг талаас үзүүлэгийн тодорхой цогцолборыг харгалзахгүй материалыг шилэх боломжгүй бол нөгөө талаас цөөн бус тохиолдолд материал дараагаараа үзүүлэгийн тусгай цогцолбор болдог. Ийнхүү сэдэвчилсэн бүтцэд урьд нь тусгагдаагүй нэг сэдэвт цогцолбор буюу нэг үзмэрийг тусад нь тавих шаардлага гардаг.

Үзмэр шилэхэд өмнө нь концепци, цуглуулгатай танилцан АУСШ-ээ санал болгосон зураач оролцоно. Үүний дараа үзмэр дэглэгч үзүүлэгийн эд зүйлийн каталогиос шилсэн үзмэрийн картуудыг авна. Бусад нь нөөцөд үлдэнэ. Картуудыг үзүүлэгийн цогцолборын дагуу байрлуулж үзнэ. Каталогт ерөнхий тайлбар ба туслах материалуудыг оруулна. Үзүүлэгт ийнхүү тодорхой нүүр царайтай болдог. Гэхдээ орон зайд байрлуулаагүй үед үзүүлэгийн цогцолбор байхгүй.

Үзмэрийг буруу байрлуулбал үндсэн концепци гарахгүй бөгөөд үзмэр танхимд багтахгүйд хүргэнэ. Тиймээс үзмэр дэглэгч ноорог гар зураг гаргадаг. Түүхэн үйл явдалд тухайн үзмэрийн үүрэг байр суурийн талаар зохиогчийн ойлголт туссан энэ бүдүүвч зураг зураачтай хамтран ажиллах эх болно.

IV Туршилтын өрөлт (пробка)

Шилж авсан материалыг сэдэвчилсэн төлөвлөгөө, зохиогчийн гар зураг, АУСШ-ийн төслийн дагуу өрнө. Ингэхдүү танхимын хана, хоргоны зохистой багтаамж, үзмэр зохицол, үзүүлэгийн үүрэг, зохиомжийг улам тодорхой болгодог. Өрөлтийн үр дүнг картад тусгах ба төлөвлөлтийн эцсийн баримт үзүүлэгийн сэдэвчилсэн төлөвлөгөө (ҮСТ) ба АУСШ-ийн ажлын зурагт (эскиз) ашиглана.

Зарим музей сценари буюу зохиомж хийдэг. Сценарт шинжлэх ухааны болон уран сайхны төслүүдийг нэгтгэн дарааллуулж бичнэ. Гэхдээ энэ нь заавал биш. ҮСТ, АУСШ-ийг харилцан уялдуулж хийнэ. Жижиг үзүүлэгийг дэглэх, татан буулгах, яаралтай үзэсгэлэн хийхэд ҮСТ-г өрөлтийн өмнө бичиж болно (товч схемийг хар) ҮСТ нь судалгааны ажил юм. Түүний удиртгалд үзүүлэгийн шинжлэх ухааны үндэслэл ба үзүүлэгийн шийдлийн зарчимыг өнгө.

ҮСТ-ний жишээ:

Нүүр. (музей, үзүүллэгийн бүлэг-хэсгийн нэр, танхимын дэс дугаар танхимын кв,м, сэдвийн нэр, зохиогч буюу хамт олны нэр, төлөвлөгөө гаргасан он сар өдөр)

Гарчиг. (хэсэг ба сэдвийн жагсаалтыг төлөвлөгөөний хуудастай бичнэ-товъёог)

Удиртгал

Үзүүллэгийн ангилал

Сэдэвчилсэн бүтэц-хэсэг ба сэдэв нэр. Мөн сэдэв бүрийн товч агуулга байж болно. –Ерөнхий тайлбарууд-тайлбарыг авсан ном зохиолтой нь бичнэ.

Сэдэв буюу дэд сэдэвт орж буй цогцолборуудын нэр –танхим дахь цогцолборуудын дэс дугаар

-Цогцолборт тавигдах үзүүллэгийн материалуудын жагсаалт

-Сэдвийн жагсаалтийн дарааллаар жагсаалтыг хийнэ.Үзмэрийн тухай үндсэн мэдээлэл.

Үзүүллэгийн материалын шинж чанарын тухай мэдээлэл

-эх, хуулбар, шинэчлэх-сэргээн засварлах, туслах материал, музейн дансны номер буюу эх хадгалагдаж буй газар, бусад сан хөмрөгөөс авсан болон хуулбар хийсэн

Тэмдэглэл- тайлбар (уран сайхны төсөлтэй холбогдох)-зохиомж болон уран сайхны чимэглэлийн шийдэл

Үзүүллэгийн цогцолборын хэсэг бүрийг шугамаар зааглана.

Жижиг буюу олон нийтийн музей үзүүллэгийн агуулгыг хялбарчилсан схемээр хийж болно.

Хэсэг, сэдэв, дэд сэдэв ба цогцолборын хэсэг бүрийг шугамаар зааглана.

Жижиг буюу олон нийтийн музей үзүүллэгийн агуулгыг хялбарчилсан схемээр хийж болно.

Хэсэг, сэдэв, дэд сэдэв ба цогцолборын нэр

Цогцолбор бүрийн үзүүллэгийн материалыг товч шинж чанар ба дансны номертой бичнэ.

Тэмдэглэл-тайлбар

Үзүүллэгийн сэдэвчилсэн төлөвлөгөө хийхээс өмнө шинжлэх ухааны туслах материал диорам, үзмэр шинэчлэхэд шаардлагатай мэдээ гэх зэрэг зүйлийг бүрдүүлэх буюу боловсруулна. Энэ үед каталог ба бусад баримт бичгийг ашиглан хаяг тайлбар болон бусад баримт бичгийг ашиглан хаяг тайлбар болон бусад тайлбарыг бичдэг. Тэдгээрийг хяналж засварласны дараа удирдлагаар батлуулна. Энэхүү тайлбар ба туслах материалын бүрдүүлэлтийн бичиг баримтыг ҮСТ-д хавсаргана.

Үзүүллэг төлөвлөлтийн явцад сурталчилгааны ажил явагдана. Үзүүллэгийн зохиогчид тайлбарлагч нарт хичээл зааж, судлах ном зохиолыг хэлж бичиг баримттай танилцуулан, шилж авсан үзмэрийг харуулна.

Тайлбарлагчийг бэлтгэх ажил нь дэглэн үзмэрт дадлага хийн, тусгай комисс шалгаснаар дуусна. Тайлбарлагч нээлтийн ёслолын өмнө бэлтгэгдсэн байх ёстой.

Ажлын карт ба ҮСТ-ний үндсэн дээр танилцуулга (хуудас, нугалбар)-ыг бэлтгэнэ. Нээлтийн ёслолын зочид болон үзэгчдэд үзүүллэгийн мэдээлэл өгөх зүйтэй. Радио, телевиз, хэвлэлд өгөх ярилцлагыг бэлтгэсэн байх шаардлагатай. Мөн зураачид зарлалын талаар мэдээлэл, бэлэг дурсгал, тэмдэг зэргийн тухай саналаа эртхэн хэлэх хэрэгтэй.

Үзүүллэгийн бэлтгэл ажилд сан хөмрөгийн албаны ажилтнууд

идэвхтэй оролцдог. (схемийг харах) Тэд хэрэгтэй материалыг олж авах, эрдэм шинжилгээний ажилтан ба зураачдад зөвлөлөгөө өгч, нэмэлт дутуу материалыг цуглуулахад оролцоно.

Эрдэм шинжилгээний ажилтан-үзмэр дэглэгч (арга зүйч) АУСШ-ийн явцад оролцож, уран сайхны гүйцэтгэл, туслах материал, тайлбар зөв дэглэсэн эсэхийг шалгаж, дэглэлт чимэглэлийн ажлын хамгаалалтыг ажиглаж, дэглэлтэд оролцож, хүлээн авах комисст танилцуулж, нээлтэд ирсэн зочдод зөвлөлөгөө өгнө.

Нээлтийн ажиллагаа тусгай зааврын дагуу явагдана. Нээлтийг хамгаалалт-байр зүйн жагсаалт дагалдана. Төслийн бичиг баримтыг тогтоосон хугацаанд музейн судалгааны архив өгөх бөгөөд түүний нэг хувийг үзүүллэг дэглэлтийн албанд лавлагааны материал болгон хадгална. Мөн үзүүллэгийн картуудыг хадгална.

Үзүүллэг нээгдсэний дараа ажил дуусахгүй. Түүнийг байнга анхаарахаас гадна шинжлэх ухаан, музей судлалын хөгжил, сан хөмрөгийн баяжилт, дэглэлтийг өөрчлөх уран сайхны шинэ боломжийн хирээр шинэчлэж байна. Түүнчлэн тусгай судалгаа, санал хүсэлтийн дэвтэр, үзэгчийг ажиглах, снал солилцох, аялал зэргийн үед авсан санал хүсэлтийг харгалзаж үзнэ.

Үзүүллэгийн дэглэлтийн ажлын онцлог, цар хүрээ нь тусгай чиглэлийн мэргэжилтнүүд эрдэм шинжилгээний ажилтан-үзмэр дэглэгчийг бий болгож байна. Тэд авъяас, сонирхол, бүтээлч сэтгэлгээтэй байх ёстой. Өргөн хүрээтэй мэдлэгтэй байж түүхийн ухааны хамгийн сүүлийн үеийн ололтыг сурталчилна. Судалгааны ажлын дадлага үгүй бол музейн эд зүйлийг судалж зөв шилж авч чадахгүй.

Үзмэр дэглэгч музейн бүх талын бэлтгэлтэй байх хэрэгтэй. Учир нь үзүүллэг дэглэлтийн ажил нь музейн бүх үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм. Тэрээр үзүүллэг дэглэлтийн ажлын онол арга зүйн талын тустай мэдлэгийг олж авч, үзүүллэг дэглэлтийн ажил нь музейн бүх үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм. Тэрээр үзүүллэг дэглэлтийн ажлын онол арга зүйн талын тусгай мэдлэгийг олж авч, үзүүллэг дэглэлтийг сэтгэлгээний хөгжлийн түүхийг мэдэх хэрэгтэй. Түүнчлэн практик ажлын дадал чухал: карт, гар зураг хийх, янз бүрийн материалыг дэглэх, хуулбар хийх, үсгийн хэвийг сонгох, тайлбар текстийн зохиомжийн асуудлыг ойлгодог, үзүүллэгийн хадгалалт хамгаалалтын нөхцлийг мэддэг байх хэрэгтэй.

Ялангуяа үзүүллэг зохион байгуулах нь сурган хүмүүжүүлэх ухааны шаардлагыг харгалзахгүйгээр боломжгүй гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Үзмэр дэглэж буй ажилтан сэтгэхүйн хүлээн авах чадвар, уран сайхны чимэглэлийн урлагийн орчин үеийн хандлага, дизайны асуудлыг ерөнхийд мэддэг байх шаардлагатай. Үзүүллэг дэглэж буй ажилтан зураач болон гүйцэтгэлийг хийдэг техник ажилтнуудтай байнга харьцаж байдаг. Зураачийн үүрэг үзүүллэг зохион байгуулалтад маш их боловч эрдэм шинжилгээний ажилтан бүхэлд нь үзүүллэгийг хариуцах хариуцлагаа санаж байх хэрэгтэй. Орон зайд байрлуулсан, түүхэн бодит байдлын музейн дүр төрх, цолцолбор бүрт шингээсэн үзэл санааг тусгасан танхимын дахин давтагдашгүй нүүр царай, үзэгчийн танин мэдэхүй ба сэтгэл хөдлөлийн хүрээнд нөлөөлөх үзүүллэгийн материалыг мэдрэх чадвартай болсон үед нь эрдэм шинжилгээний ажилтныг үзмэр дэглэгч боллоо гэж үзнэ.

Үзүүллэг зохион байгуулах ажлын эрдэм шинжилгээний төлөвлөлтийн схем

- Үзүүлэгийн гүйцэтгэл
 - Үзүүлэгийн төсөл, төлөвлөлт
 - Үзүүлэгийн сурталчилгаа
 - Сан хөмрөгийн албаны ажил
1. Эд зүйл материал олох, данс шүүх
 2. Материал цуглуулахад оролцох
 3. Сэргээн засварлахад өгөх
 4. Үзмэрийг өрөлтөд шилжүүлэх
 5. Үзмэрийг үзүүлэгт дэглэхэд өгөх
 6. Тайлбарлагч бэлтгэх-хичээлд оролцох
 7. Үзүүлэг хүлээж авах комиссын ажилд оролцох
- II. Үзүүлэгийн төлөвлөлт-эрдэм шинжилгээний ажилтан
1. Холбогдох ном зохиол, архивын материал, сан хөмрөгийг судлах
 2. Сэдвийг томъёолох
 3. Эрдэм шинжилгээний концепци , үзүүлэгийн зорилт
 4. Сэдэвчилсэн бүтэц
 5. Үзмэр сонгож цуглуулах
 6. Архитектур уран сайхны ерөнхий шийдэл-зураач
 7. Дэлгэрэнгүй сэдэвчилсэн бүтэц буюу сэдэвчилсэн төлөвлөгөө
 8. Үзмэр шилэн сонгох –хамтарч
 9. Өрөлт-хамтарч
 10. Эскиз-зураач
 11. Үзүүлэгийн төлөвлөгөө
 12. Танилцуулга, тайлбар, лекц бэлтгэх
 13. Танилцуулгыг хэвлэх, лекц
 14. Тайлбарлагчдад хичээл заах
 15. Тайлбарыг бичиж дуусгах
 16. Тайлбарлагчийг шалгах
 17. Дэглэх
 18. сурталчилгаа

III. Үзүүлэгийн сурталчилгаа

1. Угсралтын хуудас
2. Угсралт
3. Уран сайхны гүйцэтгэл
4. Зарлал, тэмдэг, урилга
5. Үзүүлэгийг шалгуулж, нээх зөвшөөрөл авах
6. Нээлтийн ёслол
 - Товч схем
1. Эрдэм шинжилгээний концепци
2. Дэлгэрэнгүй сэдэвчилсэн бүтэц
3. Үзмэр шилэн сонгох
4. Үзүүлэгийн сэдэвчилсэн төлөвлөгөө
5. Архитектур-уран сайхны шийдлийн төсөл
6. Өрөлт
7. Угсралтын хуудас бусад ажил дэлгэрэнгүй схемийн дагуу явагдана.

II. Музейн үзүүлэг. Үзүүлэгийн уран сайхны шийдэлт

Музейн үзүүлэгийг зохион байгуулахад өнгөт гэрэл зураг, дүрслэлийн аргыг дэглэн үзүүлэх зүйлийг дэлгэрүүлж, харуулж, үзэж харах тааламжтай

нөхцөлийг бүрдүүлж, технологи эдийн засгийн шаардлагыг бүрэн хангах ажиллагааг явуулах зорилгыг зураач хэрэгжүүлнэ.

Зураач дизайн бодит эд зүйлийг туслах үзүүлэн материалтай нэгдэн тодорхой агуулгыг илэрхийлэх боломжийг ашиглана. Зарим тохиолдолд цогц бүтцэд үзмэрээ базаж чадаагүй бичиж зурсан зүйл нь хэт ихэдсэн орон зайн зохиомж нь багадсан зэргээс үзмэрийн баялаг мэдээлэл газар зүйн өвөрмөц шинжийг илэрхийлж гаргаж чадахгүйд хүргэнэ. Үзүүлэг цогцолборыг бүрдүүлж байгаа хэсэг үзмэрийн тухайн үзмэрийн тухайн үзмэрийг тухайн орон зайд дэглэн байрлуулахад зураачийн авъяас чадвар илэрдэг. Зураач хамгийн гол илэрхийлэл болгон үндсэн хэсгээ тодотгож хоёрдогч зүйлийг тусгаарлан илүү зүйлийг хаах чадвартай байх ёстой. Үзүүлэгт зохицсон харьцаа хоорондын уялдаа зөв ангилал орон зайн хуваарилалт энэ бусад үзүүлэгийн уран сайхны зохицолдоог бий болгоно. Гол үзмэрийн оронд туслах зүйл дэглэн хорго, самбар зэрэг үзүүлэгийн үзмэрээс илүү анхаарал татаж, тансаг материалаар хийсэн фоныг ашиглаж түүхийг нотлох баримтыг дарах явдал явдаг. Энэ зураач үзэгчдийн сэтгэл зүйн онцлог, физиологийн бодит хуулийг үнэн тооцоолох шаардлагатай. Үзүүлэгийн уран сайхны зөв шийдэлт цогц хэлбэр нь үзэгчдэд мэдээлэл хүртээх гол хэрэгсэл болдгийг музейн үзэгчдийн дунд авсан судалгаа нотолж байна.

Иймд музейн үзүүлэгт зориулсан тусгай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж шаардлагатай байдаг. Өнгө болон үзмэрийн аргыг дэлгэц нэгдэн үзэгчдийн нүдний харааны түвшинд байрласан логик уялдаатай үзмэр зохистой дэглэлт байж чаддаг. Үзэгчдийг амраах тэдний анхаарлыг өөр сэдэв чиглүүлэх зорилгоор үзүүлэгийн гол хэсгүүдийн дунд чимэглэл бүхий зай ёстой. Үзэгчийн судалгаанаас үзэхэд үзмэрийг 1,5-2 цаг анхааралтай үзэж чаддаг байна.

Үзүүлэгийн тоног төхөөрөмж

Үзүүлэгийн тоног төхөөрөмж нь үзүүлэгийн утга агуулгатай уялдсан үзмэрийг тухайн үзэгчдэд хүргэх нөхцлийг хангасан байхаас гадна аливаа гэнэтийн аюулаас хамгаалах болон хадгалалтын хэвийн нөхцлийг хангасан байна. Тоног төхөөрөмжийн хэлбэр хийц материал нь янз бүр байх боловч үзмэртэй харьцуулбал үзэгчдэд ямагт хоёрдугаарт байх ёстой. Тоног техникийг хийдэг хэд хэдэн арга байдаг.

1. Шаардлагатай тоног төхөөрөмжийг музей өөрөө байх
2. Шаардлагатай тоног төхөөрөмжийн захиалгыг мэргэжлийн байгууллагад өгөх
3. Мэргэжлийн байгууллагын хийсэн тоног төхөөрөмжийг өөрийн музейд шаардлагатай хэлбэрээр өөрчилж засах

Үзүүлэгийн өнгө нь музейн танхимаар үзэгчдийг хөтлөн удирдах нэг

хэрэгсэл байдаг. Өнгөний зөв шийдэлт, үзмэрийн нэг цогц болсон хүний оюун ухаанд хүртэх утга агуулгыг илэрхийлсэн байна. Хүний уураг тархи, аливаа юмыг хүлээж авах тааламжтай нөхцлийг бүрдүүлэх өнгө бол шар ногоон өнгө юм. Энэ өнгө нь нүдний харааны үйл ажиллагааг хэвийн байлгаж нүдийг түргэн ядраахаас хамгаалдаг. Улаан шар өнгө ялангуяа хэмжээний талбайтай хэрэглэвэл нүдний харааг хурдан эцээдэг тул музейн байранд хэрэглэх нь зохисгүй. Гэрэл гэгээтэй болгох зорилгоор өндөр тусгалтай өнгүүдийг үндсэн өнгөтэй хавсрах байдлаар завсрын өнгө гаргаж хэрэглэнэ. Музейн зураачийн гол анхаарах зүйл бол тухайн танхимын сэдвээс хамаарч өнгийг зөв олж

шийдэх шаардлагатай бөгөөд өнгийг хослуулан хэрэглэхдээ хэтэрхий олон өнгийг хэрэглэхгүй байх шаардлагатай

Гэрэл:

Гэрэл нь өнгөний адил үзүүлэгийн гол сэдвийг боловсронгуй илэрхийлэх хоёр хэлбэр юм. Гэрэл нь тухайн музейн барилга байгууламж цахилгааны системд хамаарна. Үзмэрийн хоёр тасаг үзэгчдэд хүргэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлж, үүний зэрэгцээ гэрлийн хортой нөлөөнөөс үзмэрийг хамгаалах арга хэмжээг зохицуулна. Тухайн үзмэрийн шинж чанараас хамаарч гэрлийн хүч байрлал нь янз бүрийн байна. XIX зууны сүүл XX зууны эхэнд байгуулагдах музейн барилга ихэвчлэн дээрээс хажуугаасаа үзмэрийг байгалийн гэрлээр гэрэлтүүлдэг байсан. Байгалийн гэрэлд ягаан туяаны нөлөө их байдал, үзмэрт муугаар нөлөөлдөг. Иймд байгалийн гэрлийг шууд тусгахгүйгээр хувиралттай тусгалыг ашиглах, эсвэл жаазанд шилжүүлж хийх, хамгаалалтын шил хийх зэрэг юм.

Гэрэлд хэт мэдрэмтгий үзмэрийг хуулбар хийж тавих буюу

тусгай гэрэл тавина. Орчин үеийн музейн барилгууд үзүүлэгийн танхимдаа цонхгүй, тусгай гэрлийн төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Энэ гэрлийг үзмэрийн шаардлагаар өөрчилж зохицуулах боломжтой байдаг. Янз бүрийн үзмэрт зориулж гэрлийн үндсэн өнгийг зөв сонгож, зөв хослуулах нь чухал. Ж: улаан шар өнгийн хослолд ногоон өнгөтэй зүйл, цэнхэр сааралдуу болж харагдах өдрийн гэрэл зураг, даавун эдлэл, амьтан ургамлын цуглуулганд 30 ваттийн лампа тохиромжтой. Харин тосон будгийн зураг зэрэг нь бүдэг харанхуйд удаан байснаас будагны үе давхарга харлах үзэгдэл байдаг. Музейд өдрийн гэрлийг хэрэглэхдээ хэт яагаан туяаг шүүх шүүлтүүр ашиглах хэрэгтэй. Гэрлийн нөлөөг эд зүйл, янз бүрээр хүлээж авдаг. Тухайлбал, гэрлийн хүчтэй тусгалд тэсвэртэй зүйл бий. Ж: металл, шил шаазан гэх мэт. Гэрэл дунд зэргийн мэдрэмжтэй зүйл яс арьс үслэг эдлэл тосон будаг мод гэх мэт зүйл гэрэлд тэсвэргүй эд зүйл гэрэл зураг тосон будгийн зураг, цаас даавуун эдлэл эд зүйлийн гэрлийн хэт яагаан туяа муутгахаас гадна гэрлээс үүссэн халаалт бас нөлөөлнө. Эд зүйлийн дулааны хэм өөрчлөгдсөнөөс эд зүйл агших, сунах, үрчийх процесс явагдана. Гэрлийн шүүлтүүр хэрэглэж зохистой хэмжээний гэрэлтүүлэг ашигласан боловч удаан хугацаагаар гэрэлтүүлэгт байх нь муу нөлөөтэй. Ж: 30 ваттийн гэрэлд даавуугаар бүтсэн үзмэр 3-6 сар байж болох бөгөөд засварлах хугацаа нь 3 жил байна. Гэрлийг бууруулах хэд хэдэн арга байдаг. Үүнд: хурц гэгээтэй гэрлийг харлуулж будах, гэрлийн хүчдэлийг бууруулах, гэрлийн доор торон хаалт хийх, үзмэрт хөшиг хийх, гэрлийг байнга унтрааж байх эдгээр арга байна.

Музейн үзүүлэгийн уран сайхны дэглэлтийг төлөвлөх, зохион байгуулах нь

Музейн үзүүлэг дэглэлтийг уран сайхны уран барилгын хувьд

шийдвэрлэхдээ агуулга хэлбэрийн нэгдлийн зарчим баримтлах шаардлагатай. Үзүүлэгийн гол хэлбэр бол бүх хэсэг нь уялдан холбогдсон цогцолбор байдаг юм. Үзүүлэгийн уран сайхны дэглэлт нь зураач дизайнер уран барилгаас гадна түүхэн эдийн засаг, сэтгэл зүйн социологийн судлаач, сурган хүмүүжүүлэх техникийг оролцож ашиглана. Үзүүлэгийн уран сайхны чимэглэлийн ажил нь хэд хэдэн шатыг дамжина.

1. Объектыг сонгох
2. Ерөнхий шийдэлтийг боловсруулах
3. Эскиз төлөвлөх
4. Ажлын зураг гаргах

2. Ерөнхий шийдэл: Үзүүллэгийн шинжлэх ухааны концепцийг үндэслэн

ерөнхий шийдэлтийг боловсруулна. Үүнийг музейн уран сайхны зөвлөлөөр хэлэлцэнэ. Энэ нь музейн үзүүлэлэг уран сайхны хувьд ямар зарчим баримтлах ёстойг шийдвэрлэж өгөх тул сэдвийг танхимуудад хувиарлаж үзэгчдийн маршрутыг тогтооно. Зарим гол үзмэрүүдийн байршлыг шийднэ. Гэрэл өнгөний болон дуу авианы техник хэрэгсэл бусад тоног төхөөрөмжийн талаар шийдвэрлэнэ. Дээрх зүйлийг хэд хэдэн баримт бичгийн хэлбэрээр хэлэлцүүлнэ. Үүнд том хэмжээний үзмэрийг оролцуулсан гоёл чимэглэлийн талаар тусгасан барилгын хэсэгчилсэн план зураг, үндсэн танхимуудын план зураг, танхимуудын орон зайн шийдэлтийн зураг.

3. Эскиз төлөвлөгөө

Үүнд дараах зүйлийг тусгаж шийдвэрлэнэ. Үзүүллэгийн талбайн хуваар лалтыг нарийвчлан шийднэ. Үзмэрүүд, текстийн байрлал байрлуулах арга, тоног төхөөрөмжийн байрлал танхим, зарим гол үзүүлэлтийн гэрэлтүүлэг дуу авиа бусад техник хэрэгсэлийн байрлал эскизийн төлөвлөгөөг зураач график байдлаар хийх нь зохимжтой. Энэ заал бүрийг тусад нь цаасан дээр нарийвчлан зурна гэсэн үг. Энэ нь холбогдох зүйлүүдийн байршил бусад зүйл нь тодорхой тусгагдах учир макетээс давуу талтай. Зураач үзүүллэгийн орон зайг тооцоолохдоо хүний дундаж өндөртэй уялдуулан тооцох ёстой. Үзүүлэлэг 2-2,5 метрээс өндөргүй, харааны хамрах харьцаа зай нь босоогоороо 40 градус хөндлөнгөөрөө 25-30 см байна.

Үзэгчдийн харааны төвшинг 150-155 см тооцно.

Ажлын зураг гаргах

Үзмэр текст музейн байршлыг зааж техник хэрэгсэлийн талаар тодорхой тусгана. Энэ баримт бичгийг ажлын зураг гэж нэрлэнэ. Ажлын зургийг гүйцэтгэх нэмэлт хүч зураач нарыг ажлуулна. Гол анхаарах зүйл бол дүрслэх урлагийн бүтээл текст хоёрын харилцааг сайн тооцох шаардлагатай. Түүхийн музейд текст туслах материалаа мэдээлэл өгөхдөө үндсэн үзмэрээ дарахаас болгоомжлох хэрэгтэй. Ажлын зураг макет нь диорам, зурагт материал газрын зураг диорам орно. Үзүүллэгийг дэглэж эхлэхийн өмнө бичмэл материалын үгсийн хэмжээ нь хэлбэр дүрс өнгө, байрлалын шрифт нь мэргэжлийн зураачаар хийлгэх хэрэгтэй. Сонин сэтгүүлийн шрифт нь уншиж хэрэглэхэд хамгийн тохиромжтой хийж богино эсвэл хэтэрхий урт мөр нь уншихад ойлгомжгүй төвөгтэй гэдгийг анхаарвал зохино. Хамгийн зохистой өгүүлбэр нь өгүүлбэрийн дунд зай, тэмдэгт бүхий зохиомж юм.

Үзүүллэгийг дэглэх

Үзүүллэгийг сайн боловсруулж төлөвлөсөн ажил нь үзүүллэгийг богино хугацаанд дэглэж байгуулах нөхцөл нь болж өгдөг. Дэглэж байгуулах ажлыг ерөнхийд нь төлөвлөгч зураач удирдах бөгөөд тэрээр гүйцэтгэх ажлын жагсаалтыг гаргана. Үзүүлэлэг дэглэж байгуулах ажилчин, ажилтны туслах

групп ажиллана. Үзмэр өрж дэглэх үед үзүүллэгийн төлөвлөгөө чиглэлийг өөрчлөхгүйгээр зарим жижиг өөрчлөлтийг хийж болно.

Үзүүллэг дэглэж дууссаны дараа музейн удирдах байгууллага болон шинжлэх ухааны байгууллага уран бүтээлчдийн холбоо зэрэг олон байгууллагын төлөөлөгч оролцсон комисс үзүүллэгийг хүлээж авна.

Үзүүллэг хүлээж авах комисс нь акт үйлдэж, актыг музейн архивт хадгална. Үзүүллэг дэглэх ажлын зэрэгцээ шинэ үзүүллэгийн тухай зарлал сурталчилгааны үзүүлэн материалыг зураач бэлдэнэ. Үзүүллэгтэй холбогдон билет, урилга, каталог, танилцуулгад агуулгаас гадна зохиомж өнгө чимэглэлийг зохистой ашиглах нь чухал.

Музееведение. Исторический музей. 1988 он.

Номоос орчуулсан: **Д.Бумаа Ph.D**

МҮМ-н Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга